



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1349
таний -ны № -т

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Ш.ДОЛЖИН
ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн Шаравын Должингийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Шаравын Должингийн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Шаравын Должингийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (... хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Сүхбаатар дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: ⁴ хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



**ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН
СҮХБААТАР ДҮҮРГИЙН 4 ДУГЭЭР ХОРООНД
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ХУРЛЫН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ ШАРАВЫН ДОЛЖИНГИЙН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**



ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 4 ДҮГЭЭР ХОРООНД ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ШАРАВЫН ДОЛЖИНГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР


Ардчилсан парламентын тогтолцоог бэхжүүлж, боловсронгуй болгох бүхий л санаачлагыг дэмжиж, Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны иргэдийн шууд төлөөлөл болж, улс орныхоо язгуур эрх ашгийг нэгдүгээрт тавиж хүний эрх чөлөө, шударга ёсыг дээдлэнэ. Төрийн төлөөлөл болж ажиллана.

ХОРООНЫ ИРГЭД ОРШИН СУУГЧДЫН ЭРҮҮЛ МЭНД ЧИГЛЭЛЭЭР

- Хорооныхоо хэмжээнд халдварт өвчин үүсч болзошгүй нөхцөл байдлыг судалж харьяа байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
- Иргэдэд эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх болон боловсрол олгох чиглэлээр шаардлагатай ажлыг тогтмол зохион байгуулах
- Жил бүр халдварт болон халдварт бус өвчинеөс урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах чиглэлээр холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Үүнд:

- Артерийн даралт эрт илрүүлэх үзлэг шинжилгээ /18 наснаас дээш бүх иргэд/
- Чихрийн шижин эрх илрүүлэх үзлэг шинжилгээ /18 наснаас дээш бүх иргэд/
- ДОХ, БЗДӨ-өөс сэргийлэх үзлэг шинжилгээ / 18 – 45 насны иргэд /
- Элэгний В, С вирус илрүүлэх / 15 наснаас дээш бүх иргэд /
- Элэгний архаг үрэвсэл, хатууралтай иргэдийг ЭХО, хавдрын маркер, био химийн шинжилгээнд жилд 1-2 удаа хамруулах / 40 наснаас дээш /
- Ходоод улаан хоолойн хавдрыг эрх илрүүлэх үзлэг шинжилгээ жилд 1 удаа /40 наснаас дээш /
- Умайн хүзүүний хорт хавдрыг эрх илрүүлэх үзлэг шинжилгээ жил бүр /30, 33, 36, 39, 42, 45, 48, 51, 54, 57, 60 насны эмэгтэйчүүд /
- Хөхний хавдрыг эрх илрүүлэх үзлэг шинжилгээ / 20- 60 насны эмэгтэйчүүд/
- Уушигны хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээ жилд 1 удаа / 50 наснаас дээш/
- Бүдүүн, шулуун гэдэсний хорт хадврыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээ 2 жилд 1 удаа / 50 наснаас дээш /
- Хорооны Өрхийн Эрүүл мэндийн төвд эмчилгээ, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. Үүнд:



- Бүх биеийн массажны сандал, сержам орыг нэмэгдүүлэх
- Эмч, сувилагч нарын мэдлэг, чадварыг сайжруулах богино хугацааны нарийн мэргэжлийн сургалтанд хамруулах
- ЭХО - 1-3 сарын курс 1 их эмч
- Зүрх судас - 1 сарын курс 1 их эмч
- Вакцины нарийн мэргэжлийн сувилагч -3 сарын курс 1 сувилагч
- Сэргээн засах физик эмчилгээний сувилагч - 3 сарын курс 1 сувилагч
- Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж эрүүл мэндийн даатгалыг Өрхийн эрүүл мэндийн төвд бий болгон / Гэрийн эмчилгээ, өдрийн эмчилгээ, лаборатори, физик эмчилгээний / чанар хүртээмжийг сайжруулах


ДҮҮРГИЙН ТӨСӨВТ ХЯНАЛТ ТАВИХ

- Хороонд шаардлагатай байгаа ажлыг төлөвлөн төсөвт суулгуулах, шийдвэрлүүлэхийн төлөө ажиллах
- Дүүргийн төлөвлөгдөн хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудад холбогдох төрийн байгууллагуудад төлөвлөлт хийхэд иргэдийн саналд анхаарал хандуулж тэдний дуу хоолой болон ажиллах
- Хорооны иргэдийн саналыг дүүрэгт хүргэн ажиллах
- Дүүргийн бодлого шийдвэрийг хорооны иргэдэд тогтмол танилцуулах

ИРГЭД ОРШИН СУУГЧДЫН ТАВ ТУХТАЙ АМЬДРАХ, ОРЧИН НӨХЦӨЛИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

- Байгаль эхэд ээлтэй, хог хаягдал багатай үйлдвэрлэлийг дэмжиж, Хорооны хог хаягдлын менежментийг сайжруулахад анхаарч ажиллах
- Хогийн цэгүүдийг боловсронгуй болгох чиглэлээр дорвитой ажил зохион байгуулах
- Олон жилийн хур хогийн цэгүүдийг буулган иргэдийн эрүүл аюулгүй байдалд амьдроулах чиглэлээр тогтмол халдвартгүйтгэл хийлгэн ажиллах
- Хогийг ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааг төлөвлөн ажиллах
- Орчны тохижилтонд анхаарч бохирдлыг бууруулах иргэдэд тохь тухтай, тайван амьдралыг бүрдүүлэх

ГАЗРЫН ЧИГЛЭЛЭЭР



- Иргэд оршин суугчдын эрүүл, аюулгүй байдал, эрх ашгийг байнга зөрчиж иргэдийн зөвшөөрөлгүй олгогдсон **газрын наймааг** таслан зогсоож иргэд төвтэйгөөр газрын асуудлуудыг шийдвэрлэгддэг болгохын тулд ажиллах
- Иргэдийн дуу, хоолой болж шударга ёсыг тогтоох
- Нийтийн эзэмшлийн талбайг иргэдийн өмч болгож сэргээн засварлалтын ажлыг тогтмол хийлгэхээр ажиллах

ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

- Шударга ёсыг тогтоож, авилгыг халахын төлөө ажиллах
- Намчирхал, талцалыг зогсоохын төлөө ажиллах
- Өрхийн болон жижиг, дунд үйлдэрлэлийг дэмжиж ажиллах
- Үндэсний үйлдэрлэгч иргэдийг дэмжиж ажиллах
- Дундаас доогуур орлоготой иргэд, өрх толгойлсон эцэг эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг нийгмийн хalamж зайлшгүй шаардлагатай иргэдийг дэмжиж нийгмийн хамгаалал, хalamжийн бодлогыг хэрэгжүүлж ажиллах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад иргэдийн эрх ашгийг хамгаалах
- Хорооны иргэдийн аюулгүй байдлыг хангах, зөрчлийг цаг алдалгүй, шуурхай шийдвэрлэхэд оролцох

